

СҮХБААТАР АЙМГИЙН ДАРЬГАНГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 06 дугаар сарын мэдээлэл

2024.06.24.

“Овоот”

Нэг. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР.

-Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус 19 дүгээр хуралдаанаар “2024 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийх” асуудлыг хэлэлцэн батлав.

Монгол Улсын “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн 13.1.2-т “Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31 ний өдрийн дотор бүрэн дуусгах”-аар заасантай холбогдуулан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

1. Сумын Засаг даргын А/43 дугаар захирамжаар Соёлын төвд тавилга авахад гүйцэтгэгчээр “Үржих тэнгис” ХХК шалгарч 18,881.000 (Арван найман сая найман зуун наян нэгэн мянга) төгрөг,
2. Сумын Засаг даргын А/45 дугаар захирамжаар “Аман-Ус” багийн сургалт сурталчилгааны төвийн өргөтгөлд гүйцэтгэгчээр багийн иргэн шалгарч, 9,998.000 (Есөн сая есөн зуун ерэн найман мянган) төгрөг,
3. Сумын Засаг даргын А/47 дугаар захирамжаар Гадна тоглоомын талбайд тоног төхөөрөмж худалдан авахад иргэн гүйцэтгэгчээр 18,000.000 (Арван найман сая) төгрөгийн санхүүжилтээр ажлууд хийгдэж байна.

“УИХ-ЫН СОНГУУЛИЙН САНАЛ АВАХ” ажиллагаанд 30 төрийн албан хаагч ажиллаж байгаа бөгөөд 2024.06.24 нд туршилтын санал авах ажиллагааг зохион байгууллаа.

-АВТО ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГТ 601 тээврийн хэрэгсэл шалгуулахаас 524 тээврийн хэрэгсэл шалгуулж 87,1 % тай байна.

-2024.06.06. ны өдөр Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх зорилгоор аймгийн Архивын тасгийн даргаар ахлуулсан ажлын хэсэг суманд 1 хоног ажиллаж, зөвлөгөө зөвлөмж өгсөн бөгөөд сумын төсөвт 5 байгууллага дундаж үнэлгээгээр (архив 5,8 оноо, Албан хэрэг хөтлөлт 25,6 оноо) нийт 31,4 % тай хангалтгүй байгаад дүгнэлт хийж, зөрчил дутагдлыг шуурхай арилгах арга хэмжээг авч байна.

-Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ажлын хэсэг суманд 2 хоног ажиллаж, сумын ЗДТГазар, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг байгууллагуудад дотоод аудитын шалгалт хийлээ.

-2024 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар 5 байгууллага, 22 албан тушаалтнаас сонсгол хийж, тайланг файлаар хүлээн авч, ажлаа дүгнэлээ.

Сургалт сурталчилгааны чиглэлээр

2024.06.18 ны өдөр “ЦАХИМ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдвээр 2 цагийн цахим сургалтыг иргэд, төрийн албан хаагчид нийт 18 хүнийг оролцуулан НҮБ-ын дэргэдэх “Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн олон улсын иргэний нийгмийн байгууллага”-аас зохион байгууллаа. Уг сургалтыг зохион байгуулахад “Хүний эрх хөгжил төв” ТББ зуучилж өгсөн.

2024.06.13 ний өдөр аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Төрийн албаны салбар зөвлөлөөс хамтарсан “ Хүний нөөц” бүтэц орон тооны төсөл, хүчин төгөлдөр мөрдөгдөх албан тушаалын тодорхойлолт сэдвээр цахим хурал хийж, зөвлөгөө зөвлөмж өгсөн.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Тус сумын 4 дүгээр багийн нутаг Салаа хэмээх газарт нэг хотны 3 малчны 7 ишигт мялзан өвчний шинж тэмдэг илэрч 2024.06.13 ний өдөр аймгийн лаборторит дээж явуулснаар 2024.06.15 нд хариуг ирүүлж, улсын лаборторийн хариуг 2024.06.22 ны өдөр утсаар авч, мялзан өвчний онош батлагдсан тул сумын Онцгой комисс хуралдаж, тухайн хот айлын орчинд 2024.06.14 ний өдөр сумын Засаг даргын А/47 дугаар захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоосон шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шуурхай арга хэмжээг авлаа.

-Энэ ажлын хүрээнд сумын Онцгой комиссын гишүүд болон Мал эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг үүрэгжүүллээ.

-Тухайн 3 хот айлын 1500 толгой малд вакцинжуулалтыг 2024.06.15 ний өдөр вакцин хийснээс хойш дахиж хурга, ишгэнд шинж тэмдэг илрээгүй байгаа.

2024 оны хагас жилийн мал тооллогын ажлыг хугацаанд нь амжилттай зохион байгууллаа. Сумын хэмжээнд Адуу-5100, үхэр -4304 , хонь-24129, ямаа-11904 ,тэмээ-75 нийт-45510 мал тоологдов. Малын зүй бусын хорогдлын хувьд:том малын хорогдол 18971, төлийн хорогдол-19220 нийт-38191 хорогдолтой байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Сумын ОНХСангийн санхүүжилтээр “Явуулын амбулаторийн үзлэг” 2024 оны 5 сарын 25-27 өдрүүдэд тус суманд ажилласан. Үүнд: Дотор-182, Мэдрэл-152, Эмэгтэйчүүд-128, Рентген-260, оношилгоо шинжилгээ-245, ЭХОношилгоог – 250, нүд-119,Сүрьеэ-242, нийт давхардсан тоогоор 1585 хүнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан

2024.06.17-21-ны хооронд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар 160 сая төгрөгөөр эмнэлгийн машиныг бүрэн тоноглож өгсөн.



Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нөхцөлд буюу зудад мал нь хорогдож 200-400 малтай болсон 160 өрхийн жирэмсэн, хөхүүл, 0-5 насны 47 хүүхдэд “Олон найрлагат бичил тэжээл”-ийг 4 багаар тойролт хийж тараасан. Энэхүү үйл ажиллагааг ЭМЯ, ЭМГ-аас хяналт хийж газар дээр нь танилцсан.



Боловсролын чиглэлээр:

Аймгийн засаг даргын дэмжлэгээр 8,3 сая төгрөгийн өртөг бүхий 17ш камерыг сургуулийн гадна болон дотор орчинд суурилуулсан. Гадна талд 5ш, дотор орчинд 12ш камер суурилуулан, 30 хоногоор бичлэгийг хадгалж, камер ашиглах журам боловсруулан ажиллаж байна.



2024.06.12 нд Сүхбаатар аймгийн МУ-ын Зөвлөх зэрэгтэй багш нарын зүгээс зохион байгуулсан "УНШЪЯ, СЭТГЭЕ, ХӨГЖЬЕ-2024 "- ойлгон унших чадварыг хөгжүүлэх монгол хэлний массын уралдааны 1-р ангийн ангиллын "Хурдан унших чадвар"-ын төрөлд ЕБС-ийн багш Б.Батзаяа багштай 16 ангийн хамт олондоо 2-р байр эзэлсэн амжилт гаргав.



-Дорнод аймагт зохион байгуулагдсан Өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах Хөнгөн атлетикийн тэмцээний 1500м-гүйтэд хүрэл медаль хүртлээ.

2024 оны 05 сарын 25-26-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах “Уулын Дугуйн тэмцээн”-д 3 насны ангилалд 98 тамирчин оролцсоноос сумын ЕБС-ийн 3 сурагч 5-8 дугаар байрт шалгарлаа.

Сургууль, Цэцэрлэгт улсын төсвийн хөрөнгө оруулалт цэвэрлэх байгууламжийг суурилуулах ажил 95 % тай хийгдсэн.



Соёлын чиглэлээр:

Соёлын биет болон биет бус өв тээгчийг илрүүлэх, судлах, сумын 2025 онд тохиож буй 100 жилийн ой угтсан “ДАРЬГАНГА ТҮМНИЙ ДУУЛАЛ” урлагийн бага наадмыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 5,7 сая төгрөг зарцуулсан.



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярт зориулсан "НАРНЫ ХҮҮХДҮҮД" баярын арга хэмжээ өргөн дэлгэр зохион байгууллаа.



Улс орон даяар 35 дахь жилдээ зохиогдож буй "ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР 2024" амжилттай зохион байгуулагдлаа.



Байгаль орчны чиглэлээр:

Сумын хэмжээнд 1350ш мод тарьсанаас цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд 500ш айл өрхийн хашаанд 700ш, алтан овооны хашаанд 150ш, 8775000 төгрөгний үнэ бүхий модыг хандиваар суулгах ажилд 4 ААНБ, 120 иргэн албан хаагч хамрагдсан, АДАПТ төслийн санхүүжилтээр Ганга нуурын орчинд 30га талбайд 24000ш мод тарих ажилд орон нутгаас 10 иргэн ажлын байраар ханган ажилласан бөгөөд модны ургалт 90 % тай байна.

Нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж, албан газруудад байр гудамжийг хуваарилаж 100 Төрийн албан хаагч, 250 иргэн хамрагдсан. 2 тн ахуйн хог цэвэрлэж хог тээврийн машинд ачуулсан. 150000 төгрөг зарцуулсан.

Мөн сумын төвийн ойр орчим нуур , булаг уст цэгийн сэг зэм, хогийг цэвэрлэх ажлыг БЦГХЗ болон малчидтай хамтран Бог бод нийлсэн 500 гаруй сэг зэмийг цуглуулж устгалын цэгрүү зөөвөрлөсөн. 70л тулш зарцуулсан 20 төрийн албан хаагч 10 иргэн хамрагдсан.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН

МЭРГЭЖИЛТЭН

Д. МӨНХЗУЛ

ХЯНАСАН

СУМЫН ЗАСАГ ДАРГА

Д. БОЛДБААТАР